

АСГАТ СУМЫН 2023 ОНЫ 04 САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023 оны 04 сарын 27-ны

өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Ажлын хэсэг гарч хөдөөгийн 3-н багийн суурь өрхүүдээр явж хаваржилтын байдалтай газар дээр танилцаж төр засгийн бодлого шийдвэр, өөрсдийн гаргасан шийдвэрүүдийг танилцуулан 2024 оны ОНХС-гаар хийгдэх ажлыг танилцуулж, гал түймэрээс урьдчилан сэргийлэх, малын тоо толгойн татвар төлөх болон цаг үеийн ажлыг танилцуулж ойрд хийгдэх ажлыг танилцуулж ажилласан.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

2023 оны 04 сарын 20- нээс эхлэн төсвийн хуваарийг татуулах болон тулган баталгаажуулах ажил хийгдэж нягтлан бодогч нар хуваарийн дагуу гүйлгээ хийгдэж эхэлж байна. Санхүү албаны мэргэжилтэн Г.Ариунзул сар болгоны гүйлгээг хийж гүйцэтгэн ажиллаж төсөвт газруудын жилийн тайланг гаргуулан авч Э-тайланд нэгтгэн бүх байгууллага дүгнэлт гарсан.04 сарын 26-ний байдлаар санхүү албаны гүйлгээ эхэлж өөрсдийн ажил үүргийн хуваарьт ажлыг хийж гүйцэтгэж байна. 2023 сарын шилэн дансны мэдээллийг улирлаар илгээх ажиллаж байна. Нийт гүйлгээ 213 байна.

Төрийн сангийн орлогын дансанд

1. Бууны албан татвар-210,000
2. Хөрөнгийн орлого – 7,369,885.83
3. Шууд бус орлого – 14,200
4. Улсын тэмдэгтийн хураамж татвар -27,000
5. Газрын төлбөр 6,171,675
6. Торгуулын орлого –,2,475,000
7. Үйл ажиллагаа - 0
8. Малд ногдуулах татвар – 11,650,200
9. Хөрөнгө борлуулсны орлого- 1,148,301.73
10. Цалин хөлс түүнтэй адилтгах -33,708,888.43
11. Газрын төлбөр – 7,214,055

12. Бусад орлого – 10,000,000

Аймгаас авах санхүүгийн дэмжлэг нийт 178,377,600 орж ирсэн ба 280,091,600 төгрөгийн санхүүжилт орон нутгийн газрууддаа олгосон байна. Одоогийн байдлаар 910 татварын дансанд 84,936,408 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ОНХС тендэр зарлагдаж байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Хөдөөгийн суурь өрхөөр сумын засаг даргын ажлын хэсэгтээ хамтран нийт 80 өхийн 140 хүнд хөдөө аж ахуйн тасгаас хийж гүйцэтгэх ажил “ малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хууль” Малын генетек нөцийн тухай хуулийн яриа таниулга хийсэн.

Сүхбаатар суманд зохион байгуулсан бэлчээрийг зөв зохистой ашиглах бэлчээрийн хэлэлцүүлгэнд 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.

Бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх ажлын хүрээнд тархалтын зургаллыг “гаргаж Аймгийн хөдөө аж ахуйн газраас” Шим “ ААН-ийн үйлдвэрийн” Бактобротадиолоны бэлмэл” мэрэгчтэй тэмцэх бактерийн бэлдмэл 1.400 татаж оготоно устгал хийх ажил бэлтгэгдээд байна. Худаг ус цэг тогтоох сумын болон бэлчээрт нутагт геофизикийн хайгуулын ажлыг “ Аман хужир” Сум ын төв” Алдар” Ухаа нуур” зэрэг газруудад “ Ус амьдрал” ХХК цэг тогтоосон Төмс хүнсний ногоо тариалах иргэдийн судалгааг гаргаж засгийн газраас олгох хөнгөлттэй үнээр авах үрийг Хөдөө аж ахуйн газраас очиж авах мэдээллийг иргэдэд хүргэсэн.

Мал төлөлт нийт 52420 төлөлсөн. үүнээс Гүү -1400, Үхэр- 2000, Тэмээ-20, Хонь-30000, Ямаа-19000, хувь 45

Зүй бусаар хорогдсон мал нийт 3101 Үүнээс Адуу-98, Үхэр-226

Хонь-1345, Ямаа-1432 байна.

Мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөгөөт халдваргүй 5 өвчний, гоц халдварт шүлхий өвчний хаврын вакцинжуулалтын 18321 үхэрийг 4 сарын 28-наас эхлэн вакцинжуулалтын ажлыг гүйцэтгэх бэлтгэл ажил бүрэн хангагдсан.

Сумын Засаг даргын 2023 оны 03 сарын 23 өдрийн А/31 тоот захирамжын хүрээнд зүй бусаар хорогдсон малын хүүр сэг зэмийг цуглуулж булж устгах ажлыг багийн Засаг дарга нар ,байгаль орчны тасаг , иргэд малчин өрх нартай хамтран зохион байгуулан адуу 75, үхэр 98, хонь 780, ямаа 990, нохой 46, нийт 1989 толгоймалынхүүрсэгзэм, нийт 47616м² талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн байна.

Шүлхий өвчний тандалт судалгаанд явж 48 ш цусний дээж цуглуулан мал эмнэлгийн газартаа тушаан мал эмнэлгийн нэгдсэн системд шивж оруулах ажлыг зохион байгуулан ажилласан.

Байгаль орчин:

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хүрээнд:

Аймгийн засаг даргын Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тэмцэх арга хэмжээний тухай 02 дугаар албан даалгавар, Сумын засаг даргын Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах тухай А/29 тоот захирамжийн хүрээнд дараах ажлуудыг хийж байна. Багийн засаг дарга нар, байгаль хамгалагч, хэсгийн төлөөлөгч нартай хамтран түймрийн сэрэмжлүүлэг 140 өрх, 238 иргэн, 11 аж ахуйн нэгж хамрагдаж гарын үсэг зуруулан албажуулан баталгаажуулж ажиллаж байна. Мөн сумын цаг уурын харуултай хамтран гар утсанд массмесежийг 3 удаа, цахим хэлбэрээр гал түймэрийн сэрэмжлүүлэг мэдээг тогтмол хүргэн ажиллаж байна. Мөн гал унтраагч багаж хэрэгслийг цаг тухай бүрд нь засварлаж одоогоор 5 гал унтраагч хэвийн ажллаж байна. Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх үүрэг бүхий сайн дурын хэсгийг шинэчилэн тодотгол хийж 12 хүний бүрэлдэхүүнтэй засаг даргын А/28 тоот захирамжаар атлуулж 1 удаа сургалт зохион байгуулж ажилласан.

Хог хаягдал сэг зэмийн талаар хийсэн ажил:

Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэнд хяналтыг тогтмол хийж байна.Орчны бохирдолтой хог ихтэй газруудад засаг захиргааны үүрэг чиглэлийг хугацаанд нь биелүүлэх талаар засаг даргын 2023 оны 03 сарын 21 өдрийн А/27, А/31тоот захирамжаар нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж албан байгууллагууд 15 тн хог цэвэрлэж,зүй бусаар хорогдсон малын хүүр сэг зэмийг цуглуулж булж устгах ажлыг

багийн Засаг дарга нар ,байгаль орчны тасаг , иргэд малчин өрх нартай хамтран зохион байгуулан адуу 75, үхэр 98, хонь 780, ямаа 990, нохой 46, нийт 1989 толгой малын хүүр сэг зэм, нийт 47616м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийсэн байна.

Ногоон байгууламжийн талаар хийсэн ажил

4 сард сумын ногоон байгууламжийн мод бут суулгацыг гэмтээх, устгахаас урьдчилан сэргийлэх, модонд таналт хийх, цэнэг усалгаа, эвдэрч нурсан хашааг засаж сэлбэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Мөн сууурь өрх тойрох ажлын хэсэгтэй хамтран ажиллаж өөрийн ажлын талаарх мэдээ мэдээлийг иргэдэд хүргэсэн. Газрын тос дамжуулах хийн хоолойн түр замыг тавьж байгаа Мянган тэмүүлэл ХХК-ын үйлажиллагаанд хяналт зөвлөмж зөвлөгөө өгч, хяналт шалгалт хийж ажиллаа.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хуралдаж хуралдаанаар ахмадын асаргаа 1, харж хандах хүүхэдгүй ахмад настанд олгох түлээ нүүрсний хөнгөлөлтийг тус тус хэлэлцсэн баталсан. Сар бүрийн олголтын тулгалтыг хугацаанд нь хийж хүргүүлэн ажиллаж байна.

Ehalamj системд 0-3 насны хүүхдээ асарч байгаа эцэг эхэд олгох тэтгэмжинд 7иргэнийг бүртгэсэн. Хүүхдийн мөнгөнд 8 хүүхдийн материалыг хүлээн авч жагсаалт үйлдэн программд бүртгэн оруулсан.Жирэмсэн эхийн тэтгэмжинд 5 иргэнийг бүртгэсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжих төсөл хөтөлбөрийн талаар мэдээлэлийг хүргэж ажилласны дагуу ААЭ-ийн төсөлд 6 иргэний төсөл, ХБИ-ий төсөлд 1, ахмадын зөвлөх үйлчилгээний төсөлд 2 ахмадын төслийг холбогдох газарт хүргүүлэн ажилласан. Мөн ААЭ-ийн төсөл ХБИ-ий төсөлд ирүүлсэн иргэнийн профайлинг

үнэлгээг хийсэн. 2022,2023 онд малжуулах төсөлд хамрагдсан иргэдтэй уулзаж эргэн 4 иргэний эргэн төлөлтийг хийлгэсэн. Хугацаа хэтрэлтэй 2 иргэнтэй холбогдон зээлийг барагдуулахыг шаардан ажилласан. Ejobсистемд ажил хайгч 9 иргэнийг бүртгэсэн.

ХАБ-ийн зөвлөлийг шинэчлэн байгуулж хурал хийн сарын аяны талаар хийх ажлын төлөвлөгөөг гарган батлуулсан. ААНБайгууллагаын 58 ажилтан албан хаагчдад Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, ХАБЭА-н тухай хуулийн талаар сургалтыг ХХҮГ-ын мэргэжилтэн, байцаагч нартай хамтран зохион байгуулж АХА тэмцээн явуулсан. АМЧБО бүлгийн сургалтыг холбогдох байгууллага, мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулж 60 хүүхдийг хамруулсан.

Боловсролын чиглэлээр:

2023-2024 оны хичээлийн жилд 1-р ангид элсэн орж суралцах сурагчдын"14 ХОНОГИЙН ХӨГЖҮҮЛЭХ “ сургалтыг зохион байгуулж 1-р ангид элсэн суралцах сурагчиддаа урилга өгч ажилласан. Нийт 40 сурагч бэлтгэл ангид суралцаж байна.

Эцэг эх, багш,ажилчид, сурагч хүүхдүүдийн дунд төрөл бүрийн уралдаан тэмцээн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байгаа ба эцэгэх, асранхамгаалагчдындунд "ХӨГЖӨӨНТ МАТЕМАТИК" тэмцээн, "Аав, ээж, би" хөгжөөнт цэнгээнт тэмцээн, холимог волейболын тэмцээнийг 6-9 дүгээр ангийн сурагч, эцэг эхчүүдийн дунд, сурагчдын дунд Нөхөрсөг буухиа, Оюун ухааны тэмцээн, гар бөмбөг, сагсан бөмбөгийн тэмцээнүүдийг зохион байгуулан ажилласан.

Мөн Сүхбаатар аймгийн өсвөр үеийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнд Д.Зоригт дасгалжуулагчтай волейболын секцийн сурагчид амжилттай оролцож эмэгтэй баг 2-р байр, эрэгтэй баг 4-р байрыг эзэлсэн ба эрэгтэй шилдэг давуулагчаар 7а ангийн сурагчБ.Зөнбилэг, эмэгтэй шилдэг давуулагчаар 9а ангийн сурагч Э.Эмүжин нар шалгарсан. Өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах Үндэсний бөхийн барилдаанд 9а ангийн сурагч Г.Мөнх-Оргил хүрэл медаль, 5а ангийн сурагч Э.Сугар-Эрдэнэ уран гараа дэвээтэй бөхөөр шалгарсан.

Архивын ерөнхий газар болон аймгийн архивын газартай хамтран зохион байгуулсан Архив албан хэрэг хөтлөлтийн 2 өдрийн сургалтад номын санч-бичиг хэргийн ажилтан

хамрагдсан. Байгууллагын гадна орчны хогийг цэвэрлэж, бүх нийтийн цэвэрлэгээнд хамрагдаж нүүрсний хог хаягдлыг бүрэн цэвэрлэсэн

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

З.ЯДАМЖАВ.